

#Гадаад_эмэгтэйчүүд #Metoo #WithU #Good_bye_Бэлгийн_хүчирхийлэл

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн гадаад
эмэгтэйчүүдэд тусламж үзүүлэх танилцуулга



Бэлгийн хүчирхийлэл гэдэг нь?

Бэлгийн хүчирхийлэл, бэлгийн халдлага болон дарамт, цахим орчин дахь бэлгийн хүчирхийлэл, биеэ үнэлэх болон биеэ үнэлэхийг хэн нэгэн шаардахыг хэлнэ.

01

Бэлгийн хүчирхийлэл

Би хүсээгүй байхад хүч хэрэглэн бэлгийн үйлдэл хийх



02

Бэлгийн халдлага болон дарамт

Миний биеийг оролдох, бэлгийн сэдлээ тоглоом наргианы үг хэллэг болон үйл хөдлөлөөр илэрхийлэн таагүй сэтгэгдэл төрүүлэх



03

Цахим ертөнц дахь бэлгийн хүчирхийлэл

Зөвшөөрөлгүй миний биений зургыг авах юм уу бусдад тараах



04


Биеэ үнэлэх

Өөрийн биеэ үнэлэх болон биеэ үнэлэхийг хэн нэгэн шаардах



Миний эргэн тойронд болж буй бэлгийн хүчирхийлэл

Дотны харилцаанаас үүдэж буй бэлгийн
хүчирхийлэл



Солонгосын бэлгийн хүчирхийлэлд өртсөн иргэдэд зөвлөгөө өгөх төвийн 2018 онд зөвлөгөө өгсөн байдал

Би болон миний эргэн тойрны хэн ч байсан
бэлгийн хүчирхийллийн хохирогч болж болно.



✓ Гэр бүл дэх бэлгийн хүчирхийлэл

Гэр бүл цуцалвал шууд хөөгдөнө хэмээн сүрдүүлж буй эр нөхрийнхөө бэлгийн хүчирхийлэлийг дагжин чичирч тэвчсээр байна.

(2018. 02. 28 Дуна илбү сонин)



✓ Ажлын байран дахь бэлгийн хүчирхийлэл

Ажлын байрандаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн гадаад эмэгтэйчүүд оршин суух эрхээ алдахаас болгоомжилж цагдаад мэдүүлэг өгч чадахгүйд хүрч байна.

(2019. 04. 24 Гёнхан сонин)



✓ Сургуулийн орчин дахь бэлгийн хүчирхийлэл

Гадаад оюутанд бэлгийн дарамт үзүүлсэн гэсэн шалтгаанаар барилгын эзэнд хэрэг үүсгэв.

Гадаад оюутанууд бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх арга барилыг сайн мэдэхгүй байна.

(MBC мэдээ)

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн бол заавал нөхөр болон бусад гэр бүлийн гишүүдээ, хамт ажилдаг хүндээ эсвэл даргадаа, найз нөхөд болон хамт суралцдаг хүн мөн багшдаа хандан тусламж хүсээрэй.

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн бол яах ёстой вэ?

01

Өөрөө бэлгийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд

тусламж хүсэх

112

цагдаад мэдэгдэх

02-733-0120

Орчуулгын үйлчилгээ үзүүлдэг гадаад эмэгтэйчүүдэд зориулсан мэргэжлийн зөвлөгөө өгөх төвд хандах



Бэлгийн хүчирхийлэлд өртвөл (72 цагийн дотор)



цагдаад мэдэгдэнэ.



Орчуулгын үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргана.



Миний бие бодит баримт болно. Мэдэгдэл өгсөний дараа арчиж, угааж, эмчилгээ хийлгэнэ.



Хүчирхийлэлд өртсөн тохиолдолд гадаад эмэгтэйчүүдэд зориулсан мэргэжлийн зөвлөгөө өгөх төвд хандана.

02

Миний эргэн тойрны хүмүүс (гэр бүлийн гишүүн, найз нөхөд, хамт ажилдаг хүн) бэлгийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд

✓ хүчирхийлэлд өртсөнийг нь сонсон хэт гайхан, айж цочирдсоны хэрэггүй шүү.

✓ Хохирогч удаан, тайван нөхцөл байдлыг ярих боломжыг олгож сайн сонсох хэрэгтэй.

✓ Хохирогчыг аюулгүй газар хамгаалах хэрэгтэй.

✓ Хүчирхийлэлд өртөөд удаагүй бол хохирогч нотлох баримт үлдээхэд нь тусалж өгөөрэй.

✓ Мэргэжлийн зөвлөгөө хэрэгтэй гэж үзвэл гадаад эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх төв рүү хандана уу.



Бэлгийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд Сөүл хотын гадаад эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх төвөөр дамжуулан авч болох тусламжтай танилцъя.

01

Оршин суух эрх

- ✓ **Нөхрийнхөө үгийг сонсохгүй бол эх орон руу чинь хөөнө гэж сүрдүүлж байна уу.**

Санаа зовсоны хэрэггүй. **Нөхөр чинь таныг эх орон руу тань хөөх эрх байхгүй.** Харин ч таныг хохироогч нөхөр чинь өөрөө ял шийтгэл хүлээнэ.

- ✓ **Ажлын байр сольж өгөх хүсэлт гаргахад хууль бус хэмээн хүлээн зөвшөөрөхгүй байна уу.**

Огт үгүй. **Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогч зүй ёсны дагуу ажлын байраа сольж болно.**

Хохироогч таныг ажлаас халах, эх орон руу тань хөөх эрх байхгүй.

- ✓ **Сургуулийн орчинд бэлгийн хүчирхийлэлд өртсөн бол тусламж авах боломжгүй.**

Санаа зоволтгүй. **Гадаад эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх төв бэлгийн хүчирхийлэлийн эсрэг таньтай хамт тэмцэх болно.**



- ✓ **Гадаад иргэний бүртгэлд бүртгүүлээгүй иргэд тусламж авах боломжгүй юу?**

Боломжтой. Гадаад иргэний оршин суух визний ангилал хамаарахгүй бүх хүн тусламж авах боломжтой.

Гадаад иргэний бүртгэлд бүртгүүлээгүй иргэн хэмээн хүчээр эр орон руугаа хөөгдөх учиргүй.

- * **Гадаад иргэний бүртгэлд бүртгүүлээгүй иргэнийг мэдэгдэх үүрэг бүхий тогтолцоо үгүй болсон.**

Хохирогч гэмт хэргийн хохиролын мэдүүлэг өгч байгаа үед Гадаад иргэд бүртгэлийн газрын хязгаарлалтаас чөлөөлөгдөх болно.

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд
Сөүл хотын гадаад эмэгтэйчүүдэд зөвлөгөө
өгөх төвөөр дамжуулан авч болох тусламжтай
танилцъя.

02

Зөвлөгөө

✓ Хохироогчтой хууль зүйн талаар яаж заргалдах вэ?

Санаа зоволтгүй. Гадаад эмэгтэйчүүдэд зориулсан мэргэжлийн хууль зүйн зөвлөгөө өгч хохироогчтой заргалдаж болно.

✓ Бэлгийн хүчирхийлэлд өртөн бэртэл авсан бол яах ёстой вэ?

Бэлгийн хүчирхийлэлийн улмаас үүссэн бэртэл гэмтэлийг эмнэлэгийн тусламж аван эмчилгээ хийлгэх боломжтой.

✓ Бэлгийн хүчирхийлэлд өртөн сэтгэл зүйн хүнд цохилтонд орсон тохиолдолд яах ёстой вэ?

Санаа зоволтгүй. Сэтгэл зүйн зөвлөгөө болон эмчилгээгээр дамжуулан өдөр тутмын амьдралаа үргэлжлүүлэх итгэл найдварыг олж аван сэтгэл санааны тайван тогтвортой байдлаа хадгалж болно.



✓ Солонгос хэл сайн мэдэхгүй ээ, өөрийнхөө нөхцөл байдлыг яаж тайлбарлах вэ?

Зүгээр ээ,
Итгэж болох зөвлөгчийн тусламжыг авч болно.

✓ Зөвлөгөө авсан тохиолдолд хохирогч миний байдал олонд зарлагдах уу?

Огт үгүй.
Зөвлөгөө авсан үед ярилцсан бүх яриаг нууцална.

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд
Сөүл хотын гадаад эмэгтэйчүүдэд зөвлөгөө
өгөх төвөөр дамжуулан авч болох тусламжтай
танилцъя.

03

Хамгаалах

✓ Яг одоо очих газар байхгүй яах вэ?

Санаа зоволтгүй ээ. **Хамгаалах байранд та аюулгүй байж болно.**

✓ Ганцаараа цагдаагийн газар болон шүүхэд очихоос айгаад байна.

Санаа зоволтгүй ээ. **Итгэж болох орчуулагч зөвлөгч хамт явах болно.**

✓ Намайг хэрхэн өмгөөлөх вэ?

Хохирол амссан тань **батлагдвал өмгөөлөгч авах боломжтой.**

✓ Хохироогч байнга сүрдүүлж зовоож байна.

Хохироогчын хүчирхийлэлийн ял шийтгэл тэр хэмжээгээрээ нэмэгдэх болно.

Хохироогч дахин хайж ирэх боломжийг таслан зогсоож, хууль зүйн арга хэмжээ авах болно.



04

Төлбөр

✓ Тусламж авах тохиолдолд төлбөр гарах уу?

Үгүй ээ. **Хууль зүйн, эрүүл мэндийн, сэтгэл зүйн зөвлөгөөг үнэгүй авч болно.**

05

Бусад

✓ Хохироогч нь гадаад хүн байсан ч хамаагүй тусламж авч болох уу?




Мэдээж тусламж авах боломжтой.


Гадаад иргэдийн хооронд болсон бэлгийн хүчирхийлэлийн хохироогч ч мөн адил тусламж авах боломжтой




✓ Тусламж авахын тулд юу бэлдэх вэ?




Хүчирхийлэл өртсөн гэдгийг нотлох баримтыг маш нягт нямбай цуглуулж авах нь зүйтэй. **Юу юунаас илүү хамтдаа аюултай эгзэгтэй цаг мөчийг давж туулна гэдэгт итгэх бат итгэлтэй байх нь хамгийн чухал зүйл юм.**




Бэлгийн хүчирхийлэлийн тухай асуулт хариулт




 Q Би өөрөө болгоомжтой байвал бэлгийн хүчирхийлэлд амархан өртөхгүй.  / 




 Q Бэлгийн хүчирхийлэлд өртөх үед би өөрөө эсэргүүцэхгүй бол тусламж авч чадахгүй.  / 




 Q Таньдаг хүндээ ч гэсэн бэлгийн хүчирхийлэлд өртөж болно.  / 

 Q Нөхрийн хүчээр шаардаж буй бэлгийн харьцаа ч мөн адил бэлгийн хүчирхийлэлд хамаарагдана.  / 

Q Хамт олноороо хоол идэж байхад өртсөн бэлгийн хүчирхийлэл ч мөн адил ажлын байран дахь бэлгийн хүчирхийлэлд багтана.  /  

Q Хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хурдан биеэ угаах ёстой.  /  

Q Бэлгийн хүчирхийлэл үйлдэгч нь сэтгэцийн гажигтай юм уу, гэмт хэрэгт холбогдож байсан этгээд байдаг.  /  

Q Бэлгийн хүчирхийлэлд өртсөн ч гэсэн нүдэнд ил харагдах шарх үүсэхгүй байж болно.  /  

Сөүл хотын гадаад эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх төв

Сөүл хотын гадаад эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх төв

Сөүл хотын гадаад эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх төв нь бүх төрлийн хүчирхийлэлд өртсөн гадаад эмэгтэйчүүд ба олон соёлт гэр бүлд зориулан мэргэжлийн зөвлөгөө өгч байна

- ✓ Олон орны аман болон бичгийн орчуулга
- ✓ Утсаар зөвлөгөө өгөх
- ✓ Он-лайн зөвлөгөө өгөх
- ✓ Биеэр ирж зөвлөгөө авах
- ✓ Сэтгэл зүйн зөвлөгөө
- ✓ Хууль зүй болон эрүүл мэндийн үйлчилгээ холбож өгөх

Ханөлтари хамгаалах байр

Ханөлтари хамгаалах байр нь эрсдэлтэй аюултай нөхцөлд буй гадаад эмэгтэйчүүд болон тэдний гэр бүлийн аюулгүй байдлыг хамгаалах газар юм.

- ✓ Түр хамгаалах байр(3 сар)
- ✓ Хувь хүнд зөвлөгөө өгөх
- ✓ Бүлэг хүмүүст зөвлөгөө өгөх
- ✓ Гэр бүлд зөвлөгөө өгөх
- ✓ Хүүхдийн сэтгэл зүйн засал
- ✓ Хохирогчидыг эмчлэх хөтөлбөр



Бэлгийн хүчирхийлэл болон дарамт хандлагад өртсөн гадаад эмэгтэйчүүдэд мэргэшсэн зөвлөгөө өгөх

Бэлгийн хүчирхийлэл болон дарамт хандлагад өртсөн хохирогчдод зориулан аман болон бичгийн орчуулга, эрүүл мэнд·хууль зүй·сэтгэл зүйн зөвлөгөө өгөх Нэг цэгийн үйлчилгээг явуулж байна.

Зөвлөгөө өгөх

- ✓ Яаралтай үед туслах
- ✓ Яаралтай үед асуудалд оролцон шийдвэрлэх
- ✓ Олон орны аман болон бичгийн орчуулгын үйлчилгээ
- ✓ Кейс бүртгэх ба зохицуулах
- ✓ Бүс нутгийн холбогдох байгууллагатай холбох

Эрүүл мэндийн тусламж

- ✓ Эрүүл мэндийн байгууллагатай холбох
- ✓ Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлэхэд туслах
- ✓ Эмчилгээний төлбөрийн тусламж
- ✓ Бусад эрүүл мэндийн тусламж

Сэтгэл зүйн зөвлөгөө

- ✓ Хохирогчид болон тэдний гэр бүлийн сэтгэл зүйн аюулгүй байдлыг хангах
- ✓ Олон орны аман болон бичгийн орчуулгын үйлчилгээ
- ✓ Сэтгэл зүйн тест болон зөвлөгөө өгөх
- ✓ Гадаад эмэгтэйчүүдэд зориулсан мэргэжлийн зөвлөгөө өгөх байгууллагатай холбох

Хууль зүйн зөвлөгөө

- ✓ Шүүхэд нэхэмжлэл өргөдөл гаргахад засаг захиргааны тусламж үзүүлэх
- ✓ Хууль зүйн зөвлөмж, шүүхэд нэхэмжлэл гаргах хууль ёсны төлөөлөгчтэй холбох
- ✓ Гадаад эмэгтэйчүүдийн хэргээр дагнасан өмгөөлөгчтэй холбох
- ✓ Хэрэг явдлын шүүх хуралд хамт оролцох
- ✓ Шүүх хэргийн талаар зөвлөх ярилцах

Хамгаалах байраар хангах

- ✓ Эрүүл мэнд·хууль зүй·сэтгэл зүйн тусламж үзүүлж буй хугацаанд аюулгүй байдлыг хангах
- ✓ Бие сэтгэлийг тайвшруулах хөтөлбөр
- ✓ Бие даан амьдрахад туслах хөтөлбөр

Бэлгийн хүчирхийлэл болон дарамт халдлагаас урьдчилан сэргийлэх

- ✓ Хөтөлбөрт оролцогсодын онцлогт тохирсон программ
- ✓ Мэргэшсэн гадаад лекторын явуулын сургалт

Зөвлөгөө авах боломжтой хэл

- ✓ Монгол, вьетнам, хятад, филиппин, англи, солонгос (бусад хэлээр зөвлөгөө авахыг хүсвэл урьдчилан цаг авна уу)

Тусламж авах байгууллагыг танилцуулъя

Хохиролыг мэдэгдэх байгууллага	Цагдаагийн газар	112
Хүчирхийлэлд өртсөн гадаад эмэгтэйчүүдэд мэргэжлийн зөвлөгөө өгөх газар	Сөүл хотын гадаад эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх төв	02-733-0120
	Инчон хотын гадаад эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх газар Саллоун	032-441-9797
	Тэгү хотын гадаад эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх газар	053-944-2977
	Чүнбүг хүчирхийлэлд өртсөн гадаад эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх газар	043-223-5253
	Жоннам гадаад эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх газар	061-282-1562
24 цагийн гадаад эмэгтэйчүүдэд яаралтай зөвлөгөө өгөх газар	Танүри төв	1577-1366
Биеэ үнэлэх хүчирхийлэлд өртсөн гадаад эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх газар	Дүрэбан	031-841-2609
Бэлгийн хүчирхийлэлд өртөгсдөд мэргэжлийн зөвлөгөө өгөх газар	Солонгосын бэлгийн хүчирхийлэлд өртөгсдөд зөвлөгөө өгөх газар	02-338-5801

О/Х Асуулт хариулт : X, X, O, O, O, X, X, O

Сөүл хотын гадаад эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх төв

Утас : 02-733-0120


FAX : 02-735-0120

и-мэйл : smf0120@hanmail.net

Вэб хуудас : www.smf0120.modoo.at

Нүүр ном : http://www.facebook.com/smf0120

Хаяг : Сөүл, Жонгно, 38, Сөүл Глобал төвийн барилга
Сөүл хотын Гадаад эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх төв (03188)



#Гадаад_эмэгтэйчүүд
#Metoo #WithU
#Good_bye_Бэлгийн_хүчирхийлэл

Сөүл хотын гадаад эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх төв
Зөвлөгөө рүү очно уу

